



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.10.16 № 03/1965

танай _____-ны № _____-г

Тодруулга оруулах тухай

Тус газраас зарласан НХААГ/20240101539 дугаартай "Сүхбаатар дүүрэг, 9, 11-р хороо, Алтайн гудамжнаас Галданбошигтын гудамж хүртэл, 7-р хорооллын шинэ гол гудамж зам"-ын ажлын тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга хүссэнтэй холбогдуулан дараах тодруулгын хариуг хүргүүлж байна.

№	Оролцогчийн тодруулга	Захиалагчийн тодруулгын хариу
1	"Сүхбаатар дүүрэг, 9, 11-р хороо, Алтайн гудамж хүртэл 7-р хорооллын шинэ гол гудамж зам"-ын тендер шалгаруулалтын баримт бичигт ажлын гүйцэтгэгч шалгарснаас хойш 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор ажлаа дуусгахаар хуваарьтай байсан ба өвлийн ачааллаас үүдэн шинэ холболтын ажлуудыг төрийн өмчийн /УСУГ, УБДС ТӨХК, УБЦТС ТӨХК/ байгууллагууд жил бүрийн 10 сарын 15-аас эхлэн таслалт хийж шинэ холболт болон засварын ажил гүйцэтгэхийг зогсоодог мөн цаг агаарын байдлаас шалтгаалж ажил гүйцэтгэхэд хүндрэлтэй байдаг тул дээрх шалтгаанаас хамааран тухайн тендерийн ажил нь энэ 2024 онд гүйцэтгэгдэх үү, дараа жил болж хойшлогдох уу	Тус тендер шалгаруулалтад шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах шатанд захиалагчтай харилцан тохиролцож болно гэж үзэж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.